



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 1/2020

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”-ын 3.5 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/73 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын хаягийн мэдээллийг шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Ажлын хэсгийн орлогч дарга:	Ц.Билэгсайхан	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Т.Наранбаяр	ГХБХБГ-ын Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн.
Гишүүд:	Б.Мөнхчимэг	ГХБХБГ-ын Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Н.Болор-Эрдэнэ	ГХБХБГ-ын Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ц.Соёл-Эрдэнэ	Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга
	З.Урангоо	Хэрлэн сумын Газрын даамал
	Б.Одгэрэл	Хэрлэн сумын Газрын даамал

2. Хаягийн мэдээллийн сангийн өгөгдлийг газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөлтэй болон газар дээрх хаягжуулалттай харьцуулан шалгаж бүрэн, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, хуучин, шинэ зэрэгцүүлсэн хаягийн жагсаалт

231010547

2.

гаргаж, үр дүнг танилцуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА